

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гончиг	Дугаар	L049
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Баян-Уул сум
Төрсөн газар	Дорнод аймгийн Баян-Уул сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хэрийн дуган	Сүм хийдийн дугаар	ДОБУ 027
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8 сарын 4	Ярилцлага авсан хүн	Ж. Одгарьд

### Дорнод аймгийн Баян-Уул сумын Хэрийн дуган

Баян-Уул сумд хоёр хийд тэмдэглэгджээ. Нэг нь болохоор Ар Өнөрчийн хийд, нэг нь болохоор Хужиртын хийд. Энэ хийдүүдийн тухай таны мэдэх сонссон дуулсан зүйл юу байна?

Хужиртайны хийд. (нэрийг засаж хэлэв) Ар Өнөрчийн хийд гэдэг чинь Ононд байсан юм. Эсэргүү гээд баригдаж байх үед л яг тэнд л байсан даа.

-Хужиртайны хийд хаана байсан бэ?

Хужиртайн ч яахав дээ зүүн хойно модны хоршоо гэж байсан. Тэрний тэнд байсан байх юм. Миний бага байхад манай авга энэ тэр тийшээ очно гэнэ. Манай ах лам байсан юм. Ишжанцан гэдэг хүн. Хужиртайн хийдэд сууж байсан юм. Бас л нэлээн дээгүүр лам гэгдэж байсан. Ононгийн Хэрийн дуган гэдэгт сууж байсан юм. Манай ах. Тэгээд эсэргүү гээд.

-Хэрийн дуган гэдэг чинь Ар Өнөрчөөсөө өөр дуган уу?

Ар Өнөрчийн хийд гэдэг чинь Хэрийн дуганаа хэлж байгаа юм.

-Хэрийн харуулаасаа наахнаа байсан бэ?

Наана Онондоо. Ононгийн урдаа.

-Өөр ямар хурлын газрууд байв?

Тэр Хужиртайн хийд энэ бол зүүн хойно байсан юм. Өөр юм байгаагүй байх. Би ч одоо ухаан больчихоод байна. Юм мэдэхгүй.

-Хужиртайн хийд хэдэн дугантай хэр олон ламтай хийд байсан юм бол?

Би 10 хүрээгүй 7,8-тай байсан. Хужиртайн дуган гэдэг байсан гэж л сонсож байсан.(Ахыгаа байхад очиж байсан гэж хэлэх гэсэн болов уу)

-Одоо энэ хоёр хийдийг аль алийг нь сайн мэдэх хүн хэн байна?